БАТЛАВ.
ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН
ОНӨТҮГ- ЫН ДАРГА
Ё. НЯМЖАВ
2026 оны ... сарын ... өдөр

МОД, СӨӨГ ХЭЛБЭРЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 22. дугаар сарын 25 Улаанбаатар хот

№	Байршил, талбайн хэмжээ	- Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын ногоон байгууламжийн талбай.
1.	Захиалагч байгууллага	- Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ
2.	Ажил гүйцэтгэх хугацаа	- 6 дугаар сарын 22-ноос 8 дугаар сарын 07-ны хооронд ажил гүйцэтгэж дууссан байна.
3.	Агротехнологийн ажиллагаа, (голлох ажилбар)	1. **Мод, бут сөөг, ургамлан хашлага хэлбэржүүлэх.** Хот суурин газарт мод, бут, сөөг, ургамлан хашлагыг тайрч хэлбэржүүлэх зүйлшгүй шаардлага гарч ирдэг. Орчны барилга байшин, гудамж, зам талбайтай нь уялдуулан засч хэлбэржүүлэх хэрэгтэй. Мод, сөөгийг хэлбэржүүлэхэд хэлбэржүүлэлтийн багаж, хэрэгслүүдийг ашиглан тухайн мод сөөгний онцлогт тохируулан хэлбэр гаргаж засч хэлбэржүүлнэ. Бөөрөнхий, гурвалжин, дөрвөлжин, долгионтсон, шаталсан гэх мэт хэлбэр гарган хэлбэржүүлнэ. Ургамлан хашлагыг тууш дөрвөлжин, бөөрөнхий, долгионтсон гэх мэтийн хэлбэрээр засна. Хэлбэржүүлэлтийг навчит болон шилмүүст модонд 4,10-р сард, бут сөөг, ургамлан хашлаганд 5-9-р сард тасралтгүй хийнэ. Мод, сөөгний хэлбэржүүлэлт нь тухайн ургамлын гадна өнгө үзэмж, хэлбэрийг сайжруулахын зэрэгцээ ургамлын элдэв өвчин, ур, яр, хортон шавьжийг багасгах, ургамлыг залуужуулах, насжилтыг уртасгана.
4.	Ажлын хамрах хүрээ	Цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллага нь дараах ажилбаруудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

<table>
<tr><td></td><td></td><td>- Мод, бут сөөг, ургамлан хашлаганд хэлбэржүүлэлт хийх
- Таналт, тайралт хийх
- Арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх
- Хэлбэржүүлэлт хийх</td></tr>
<tr><td>5.</td><td>Ногоон байгууламжийн арчилгаа, ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд (MNS, UCS0801A:2022)</td><td>Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн стандарт:
- Ажил гүйцэтгэх явцад MNS 4969:2000 ХАБЭА-ны заавар зөвлөмжийн дагуу аюулгүй ажиллагааг сайтар баримтлан ажиллана.
- Мод, сөөг хэлбэржүүлэх ажлыг MNS 6258-2 : 2011 Мод, сөөгний суулгац арчлах стандарт, MNS 6772:2019 Мод, сөөг хэлбэржүүлэх техникийн шаардлагыг баримтлан гүйцэтгэнэ.
- Ажил гүйцэтгэлийн явцад УЦХ-ийн ерөнхий инженер болон арчилгааны инженер хяналт тавьж ажиллана.
- Ногоон байгууламжийн мод, сөөг хэлбэржүүлэлтээс гарсан хаягдлыг тухай бүрт нь сайтар цэвэрлэн авч, заасан цэгт ачиж, тээвэрлэн буулгана.
- Мод, сөөг хэлбэржүүлэх багаж, хөрөө нь шаардлага хангасан, /ир сайтай/ мод сөөг гэмтээхгүй, шалбалахгүй байна.
- Мэргэжлийн байгууллага нь ажиллах хүчний болон техник хэрэгслийн хувьд дараах шаардлагыг хангасан байна.
<table>
<tr><th>№</th><th>Албан тушаал</th><th>Тоо</th><th>Ажлын туршлага</th><th>Бусад тавигдах шаардлага</th></tr>
<tr><td>1.</td><td>Инженер</td><td>1</td><td>1 жилээс доошгүй</td><td>Ногоон байгууламжийн чиглэлээр сургууль төгссөн байх</td></tr>
<tr><td>2.</td><td>ХАБЭА хариуцсан ажилтан</td><td>1</td><td>1 жилээс доошгүй</td><td>ХАБЭА чиглэлээр сургууль төгссөн байх</td></tr>
<tr><td>3.</td><td>Туслах ажилтан</td><td>8-аас доошгүй</td><td colspan="2">Тусгайлсан шаардлага байхгүй</td></tr>
</table>
<table>
<tr><th>№</th><th>Техник хэрэгсэл</th><th>Тоо хэмжээ</th></tr>
<tr><td>1.</td><td>Портер түүнтэй дүйцэхүйц машин</td><td>2 түүнээс дээш</td></tr>
<tr><td>2.</td><td>Хэлбэржүүлэгч автомат хөрөө</td><td>Хүний тоогоор</td></tr>
</table>
</td></tr>
</table>

		3.	Хэлбэржүүлэгч хайч	Хүний тоогоор
		4.	Сунадаг шат	1-3
		5.	Угсардаг шат	1-3
		6.	Тармуур	Хүний тоогоор
6.	Цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага	- Ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээтэй байх /мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх зөвшөөрөл/ - Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин, багаж хэрэгсэлтэй байх / - Хотын ногоон байгууламжийн чиглэлээр хийсэн ажлын туршлагатай байх		
7.	Ажлын иж бүрдэл	- Төсөв - Ажлын тайлан - Бусад холбогдох материалууд		
8.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.		

ХЯНАСАН:

НББҮ ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР: **Б. ОРГИЛСАЙХАН**

БОЛОВСРУУЛСАН:
АРЧИЛГААНЫ ИНЖЕНЕР: **Д.БУЯНХИШИГ**